БАТЛАВ:

СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.ЭНХБААТАР

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилгын норм ба дүрэм стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ.

Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирүүлэх материал:

- Барилгын засварын ажил гүйцэтгэх үе шатны график
- Талбайн зохион байгуулалтын зураглал заавал ирүүлнэ үү.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийж фото зургаар баталгаажуулах,зургийн авторын хяналтын хийлгэсэн байна.

Гүйцэтгэгч Сүхбаатар аймгийн Онгон сумын 5-р багийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг гүйцэтгэнэ. Дээрхи ажлыг гүйцэтгэхдээ батлагдсан зураг төсөв /зураг төслийн шифр :/ мөн стандарт ,технологийн дагуу хийж гүйцэтгэж ашиглалтанд оруулна.

Барилгын угсралт, засварын ажил гүйцэтгэх явцад барьцалдуулах зуурмаг , шавардлага зэрэгт туршилт, сорилт, хяналт шалгалтыг талбай дээр ажлыг хийж гүйцэтгэж байх хугацаанд байвал зохино.Барилгад бүх материал нь улсын стандартад нийцсэн материал сонгосон байх шаардлагатай.

-Сагсны талбайн ажил

- Сагсны талбайг зурагт заасны дагуу 17000*26000 хэмжээтэй хийнэ.Суурийг бетоноор зутгаж резин будгаар будна.Сагсан бөмбөгийн 2 ш самбарыг стандартын дагуу хийх болон захиалж суурилуулна.Воллейболлын тор байрлуулах 2ш шонгийн нүх хийх.

-Сагсны талбайн гэрэлтүүлэг

- 200 Вт 4 ширхэг гэрэлтүүлэгийг байршуулна. Гэрэлтүүлгийн суурь 600*600*500 хэмжээтэй бетонон байна.Гэрэлтүүлгийн шон Н-8 м,3.5 мм

-Элсний талбай

- 35.3 М 3 хэмжээтэй байна.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Тохижилтын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хусэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хусэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ.

Магадлашгүй ажлыг хэрхэн, ямар ажилд зарцуулах талаар Захиалагчийг төлөөлж техник хяналт хэрэгжуулж байгаа байгууллага болон хяналтын инженерт танилцуулж, шийдвэрийг Захиалагч буюу Засаг даргын тамгын газарт гаргана. Зөвшөөлцөөгүй, танилцуулаагүй, хянагдаагүй тохиолдолд магадлашгүй ажлын зардлыг санхүүжүүлэхгүй болно. Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлын зураг теслийн зардал , захиалагчийн хяналтын зардалыг тооцож ируулэх. Дээрхи техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хуртэл арга хэмжээ авах эрхтэй.

БОЛОВСРУУЛСАН: ҮНЭЛГЭЭ ХОРОО